



МОНГОЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ
Mongol Securities Exchange

2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

Бирж 2021 оны эхний хагаст

“Монголын Үнэт Цаасны Бирж” ХК нь өөрийн эрхэм зорилгын хүрээнд үнэт цаасны арилжааг зохион байгуулах, үнэт цаас бүртгэх, арилжааны дараах төлбөр тооцоог гүйцэтгэх, төлбөр тооцооны эрсдэлийг удирдах, олон нийтийг арилжааны болон бусад шаардлагатай мэдээллээр ил тод, шуурхай хангах үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

Үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа компаниудын ирүүлсэн өргөдөл, бичиг баримтыг шалгаж, шаардлагатай зөвлөгөөг өгөхийн зэрэгцээ одоо Биржид арилжигдаж байгаа болон төлбөр тооцоо гүйцэтгүүлж буй үнэт цаас, түүнийг гаргагч компаниудад хууль, тогтоомжийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой шаардлагатай мэдээллийг хүргүүлсэн.

Бүртгэл

2021 оны эхний хагас жилийн байдлаар Биржийн Бүртгэл хариуцсан алба нь Бүртгэлийн журам болон түүнийг дагалдан батлагдах бусад журам, баримт бичгүүдийг шинэчлэхээр ажиллаж байна. Тус ажлын хүрээнд гадаад болон дотоодын биржүүдийн бүртгэлийн үйл явц, баримт бичгүүдийг судлан бүртгэлийн арга хэлбэр болон бүртгэх үнэт цаасны нэр төрлөө нэмэгдүүлэх, бүртгэлийн шалгуур болон бүртгэлийн шалгуураас хөнгөлөгдөх чөлөөлөгдөх нөхцөлийг сайжруулахаар голчлон анхаарч ажиллаж байна. Мөн Бирж нь бүртгэлтэй компаниудын мэдээллийг тогтмол хүлээн авч, шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчдад мэдээллээ хүргэхийг шаардаж ажилласан.

Бирж үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс Бүртгэлийн хороо болон Нийцүүлэгчийг бүртгэлийн үйл ажиллагаанд оролцуулдаг. Биржийн Бүртгэлийн хорооны 19 гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан бүртгэлийн хорооны гишүүнд нэр дэвшигчдийг нээлттэй сонгон шалгаруулах зар тавьж, нэр дэвшигчдийг бүртгэх ажлыг зохион байгуулсан. Бүртгэлийн хорооны бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн хурлаар батлуулахаар хүлээж байна.

Биржийн бүртгэлийн шаардлагын дагуу бирж дээр бүртгэгдсэн компаниуд нийцүүлэгчээр дамжуулан зах зээлд тогтмол мэдээ гаргадаг нь бидний давуу талын нэг юм. Нийцүүлэгчид нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө эсвэл аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд байх шаардлагатай. Хуулийн болон санхүүгийн нийцүүлэгчдийн жагсаалт шинэчлэх ажлын

хүрээнд нийт 12 санхүүгийн нийцүүлэгч, 17 хуулийн нийцүүлэгч бүртгэж, Гүйцэтгэх захирлын тушаалаар жагсаалтыг баталсан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны бүртгэлийн журам зэрэг үнэт цаасны зах зээлийн орчинд гарч буй өөрчлөлтүүдтэй холбоотойгоор банк болон санхүүгийн зах зээлийн оролцогчдын хамтарсан уулзалтуудад идэвхтэй оролцож байна.

Арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд нийт 129 өдрийн арилжаа явагдаж, 18,500 ширхэг хувьцааг 740,000 төгрөгөөр арилжигдсан байна. Оны эхний хагаст “Анд-Энерги” ХК-ийн AND хувьцааны дээд ханш 40 төгрөг, доод ханш 40 төгрөг, дундаж үнэ 40 төгрөг, 6 дугаар 30-ны өдрийн байдлаар хаалтын ханш 40 төгрөг байна.

Арилжаанд “Зэргэд ҮЦК” ХХК, “Дэлгэрхангай секюритиз ҮЦК” ХХК, “Булган Брокер ҮЦК” ХХК, гэсэн үнэт цаасны компаниуд оролцсоноос хамгийн өндөр үнийн дүн бүхий арилжааг “Дэлгэрхангай секюритиз ҮЦК” ХХК хийжээ.

Арилжааны мэдээ, мэдээллийн хувьд СЗХ-ны 2019 оны 1 сарын 09-ний 4 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1 дэх заалтын дагуу 2021 оны 1 дүгээр сараас 6 дугаар сарын арилжааны мэдээлэл болон долоо хоног бүрийн арилжааны мэдээллийг холбогдох маягтаар бэлтгэн СЗХ-нд хүргүүлсэн. Сар бүр арилжааны статистик мэдээлэл, үнэт цаасны өсөлт бууралт, зах зээлийн үнэлгээний мэдээллээс гадна сар бүр арилжааны шимтгэл, үнэт цаас гаргагчтай холбоотой ногдол ашиг, үнэт цаасны компаниудын зохицуулалттай этгээдийн үйлчилгээний хөлсний мэдээний хамт тогтмол хүргүүлж байна.

Төлбөр тооцоо

Биржээс өгсөн зөвшөөрлийн дагуу тооцооны гишүүд 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1,480,000 төгрөгийн төлбөр тооцоо гүйцэтгэсэн байна. Үүнээс “Нэрэн клиринг” ХХК 200,000 төгрөгийн, “Харз трейд ББСБ” ХХК 1,280,000 төгрөгийн төлбөр тооцоо гүйцэтгэжээ. 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6 хэлцэл хийгдсэн байна.

Биржийн бус зах зээлийн хувьд Хорооны Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам батлагдсантай холбогдуулан 2021 онд шинээр үнэт цаасны тооцооны үйл ажиллагааг гүйцэтгэхээр бүртгээгүй бөгөөд зөвхөн өмнөх жил байгуулсан гэрээний хүрээнд тооцооны үйл ажиллагааг гүйцэтгэж дуусгахаар ажиллаж байна.

2021 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар хаалттай бондын 5,637,000,000 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс “Инвескор” бондын 5,251,000,000 төгрөг, “Zeely” бондын 386,000,000 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэжээ.

2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр байгуулсан “Инвескор” бондын “Төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ”-ний дагуу 2021 оны эхний хагасын байдлаар 2,111,000,000 төгрөгийн эргэн төлөлт, 1,105,548,562 төгрөгийн бондын хүүгийн төлөлт хийгдсэн бол “Zeely” бондын хувьд 39,724,054 төгрөгийн бондын хүүгийн төлөлт хийгдсэн байна. Түүнчлэн “Инвескор” бондын хоёрдогч зах зээлд арилжигдсан бондын 543,011,342 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэлээ.

Гишүүнчлэл

2021 оны эхний хагас жилийн байдлаар бид Гишүүнчлэлийн журам болон түүнтэй холбогдон батлуулах бусад журам, баримт бичгийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, журмыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.

Түүнчлэн 2020 онд үнэт цаасны зах зээл дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй үнэт цаасны компаниудыг судалж, зах зээлийн мэдээлэл солилцож Биржийн гишүүнээр элсүүлэхээр ажиллаж байна. Тайлант хугацаанд 1 үнэт цаасны компани Биржийн гишүүн болохоор хүсэлт ирүүлсэн бөгөөд Биржээс зөвлөгөө авч, өргөдлийн материал бүрдүүлэх шатанд явж байна.

2021 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар Бирж нийт 17 гишүүн үнэт цаасны компани, 3 тооцооны гишүүн, 2 зах зээл үүсгэгчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Санхүү

Бирж 2021 оны эхний хагас жилд 740,000 төгрөгийн арилжаа хийж, 5,638,280,000 төгрөгийн тооцооны үйл ажиллагааны гүйцэтгэж, арилжаа, тооцооны шимтгэлд 883,600 мянган төгрөгийн орлого олсон байна. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт ороогүй.

2021 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар компанийн балансын нийт хөрөнгийн дүн 3.006 тэрбум төгрөг бөгөөд түүнээс 10 хувь буюу 310 сая орчим төгрөгийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн хураангуй (сая төгрөгөөр, 2021 оны II улирал)

№	Санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүд	Дүн (сая төгрөгөөр)	
		2020.06.30-ны үлдэгдэл	2021.06.30-ны үлдэгдэл
1	Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүд		
1.1	Борлуулалтын орлого	54.07	0.88
1.2	Борлуулалтын өртөг	-	-
1.3	Нийт ашиг	-	-
1.4	Хүүний орлого	0.00	0
1.5	Бусад орлого	-	-
1.6	Ерөнхий ба удирдлагын зардал	186.94	355.95
1.7	Санхүүгийн зардал	30.29	22.75
1.8	Бусад зардал	-	-
1.9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0
1.10	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
1.11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(163.09)	(377.81)
1.12	Орлогын татварын зардал	0.00	
1.13	Татварын дараах ашиг (алдагдал)	(163.09)	(377.81)
2	Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд		
2.1	Нийт хөрөнгийн дүн	3,083.88	3,006.68
2.2	Үүнээс: Эргэлтийн хөрөнгийн дүн	149.62	310
2.3	Өр төлбөрийн дүн	651.80	1,535.3

Компанийн ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн хурал

Тайлант хугацаанд Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл нийт 5 удаа хуралдаж, нийт 12 асуудал хэлэлцэн, хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар 11 тогтоол гаргаж баталгаажуулсан.

Биржийн хувьцаа эзэмшигчдийн хурал тайлант хугацаанд 2 удаа хуралдсан бөгөөд 2021 оны 05 дугаар сарын 05 хурлаар компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталж, бүрэн эрхийн хугацаа нь дууссантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр сонгосон. 2021 оны 05 сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгосон.

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

УТАС: (+976) 7000-0501, (+976) 7000-0502

ФАКС: (+976) 7011-3722

ЦАХИМ ШУУДАН: INFO@MSX.MN

ХАЯГ: 703 ТООТ ЖИБИ ПЛАЗА, 8-Р ХОРОО, СҮХБААТАР
ДҮҮРЭГ УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС